



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/111

Батноров сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын иргэн Баярсайхан овогтой Мөнх-Эрдэнэ нь 12 дугаар ангиа амжилттай төгсөж, АШУҮИС-д элсэх болсон. Ээж болох Н.Мөнхтуяа нь өрх толгойлсон эх, амьжиргааны түвшин доогуур тооцогддог тул сургалтын төлбөрт 800.000 (Найман зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламж болох 800.000 (Найман зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР